



## **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ  
АГЕНТЛАГ, ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА, СУМДЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,  
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**2024 ОН**

## АГУУЛГА

<b>НЭГ.ЗОРИЛГО</b> .....	1
<b>ХОЁР.ҮНДЭСЛЭЛ,АРГА ЗҮЙ</b> .....	2
<b>ГУРАВ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ</b> .....	3
3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ .....	4
3.3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ ....	5
<b>ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ</b> .....	9
4.1.Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	10
4.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ .....	11
4.3 Орон нутгийн шийдвэрийн үнэлгээ .....	12
<b>ТАВ.БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b> .....	13
5.1.Байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдлын үнэлгээ .....	14
5.2.Шилэн дансны хуулийн хэрэгжилт.....	15
<b>ЗУРГАА.Хэрэглэгчийн үнэлгээ</b> .....	17
<b>ДОЛОО. Дүгнэлт</b> .....	18
<b>НАЙМ. Зөвлөмж...</b> .....	19

# ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ болон нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

## ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын А/616, А/647 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж, Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Монгол улсын Засгийн газрын 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/343 дугаар захирамжаар баталсан журам, бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэл болгож аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, сумдын 2023 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагын үйл ажиллагааг А/343 дугаар захирамжаар баталсан журмын 2 дугаар хавсралт, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг 3 дугаар хавсралтад заасан баримт бичгүүдийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.4-т заасан арга зүйгээр дээрх үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ирүүлсэн тайлангаас гадна, газар дээр нь очиж холбогдох ажилтан, албан хаагчтай уулзалт ярилцлага хийх, нэгж байгууллагаас нэмэлт тодруулга авах зэрэг хамааралтай баримт бичиг болон нотолгоо, статистик мэдээлэл судалгаанд үндэслэн, зохих харьцуулалт хийж, өмнө өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

Нийт 28 агентлаг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанд 11 шалгуур үзүүлэлт, 13 сумын Засаг даргын Тамгын газар болон сумын төсөвт байгууллагын үйл ажиллагаанд 12 шалгуур үзүүлэлтээр тус тус хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн болно. Мөн 2023 оны хагас жилийн тайлангийн ирцэд үнэлгээ өгсөн ба тус үнэлгээ нь тайлагналт, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажил эрчимжүүлэхтэй холбоотой тогтоол шийдвэр, заалт бүрийн жилийн эцсийн үнэлгээнд шууд нөлөөлнө.

## ГУРАВ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

2023 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын хууль 32, УИХ-ын тогтоол 10, УИХ-ын байнгын хорооны тогтоол 44, Ерөнхийлөгчийн зарлиг 11, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 8, Засгийн газрын тогтоол 45, хуралдааны тэмдэглэл 44, Засгийн газрын албан даалгавар 6, нийт 200 заалтын хэрэгжилтийг хянан үзэж үнэлэв.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, Сум

д/д	Сум	Өөрийн үнэлгээ	ХШҮХ-ийн үнэлгээ
1	Баруун-Урт сумын ЗДТГ	98.95%	97.37%
2	Мөнххаан сумын ЗДТГ	96.42%	95.38%

3	Наран сумын ЗДТГ	83.53%	91.30%
4	Эрдэнэцагаан сумын ЗДТГ	90.98%	90.39%
5	Баяндэлгэр сумын ЗДТГ	91.20%	89.40%
6	Дарьганга сумын ЗДТГ	89.61%	87.84%
7	Халзан сумын ЗДТГ	82.20%	86.25%
8	Түвшинширээ сумын ЗДТГ	85.10%	85.10%
9	Уулбаян сумын ЗДТГ	90.38%	84.71%
10	Асгат сумын ЗДТГ	84.42%	80.23%
11	Сүхбаатар сумын ЗДТГ	80.94%	79.81%
12	Онгон сумын ЗДТГ	73.06%	74.80%
13	Түмэнцогт сумын ЗДТГ	-	-

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, Агентлаг

д/д	Агентлаг	Өөрийн үнэлгээ	ХШҮХ-ийн үнэлгээ
1	Орон нутгийн өмчийн газар	100.00%	100.00%
2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	100.00%	100.00%
3	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	90.00%	97.50%
4	Насан туршийн боловсрол төв	100.00%	97.50%
5	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	100.00%	97.19%
6	Угсаатны зүйн музей	97.00%	97.00%
7	Боловсрол, шинжлэх ухааны газар	97.21%	95.81%
8	Соёл, урлагийн газар	100.00%	95.71%
9	"Боловсрол-Өргөө" нэгдсэн дотуур байр	100.00%	94.55%
10	Онцгой байдлын газар	98.80%	94.00%
11	Жаахан шарга театр	100.00%	94.00%
12	Татварын хэлтэс	95.71%	93.57%
13	Цагдаагийн газар	100.00%	93.16%
14	Статистикийн хэлтэс	95.38%	93.08%
15	Нийгмийн даатгалын хэлтэс	95.38%	92.50%
16	Нэгдсэн эмнэлэг	95.00%	91.67%
17	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	91.67%	90.21%
18	Мал эмнэлгийн газар	98.13%	90.00%

19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	95.83%	89.60%
20	Нийтийн номын сан	94.55%	89.09%
21	Улсын бүртгэлийн хэлтэс	100.00%	87.69%
22	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	91.43%	87.14%
23	Хүнс, хөдөө аж ахуйн газар	88.21%	86.07%
24	Шүүхийн шинжилгээний алба	100.00%	84.55%
25	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	98.00%	83.67%
26	Биеийн тамир, спортын газар	84.00%	82.00%
27	Эрүүл мэндийн газар	93.57%	78.52%
28	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	87.69%	67.27%
29	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	-	-

Хууль тогтоомж, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хянаж үзэхэд дараах шаардлагуудыг хангаж тайлагнах шаардлагатай байна. Үүнд:

1. Хугацаа хоцроохгүй байх
2. 2000 тэмдэгтэд багтаан оновчтой, товч тодорхой тайлагнах зарчмыг баримтлах
3. Үг үсэг, утга найруулгын алдаагүй тайлагнах
4. Тайланд дурдагдаж буй ажил арга хэмжээний чиглэлээр гарсан шийдвэрийн огноо дугаарыг бичиж, нотлогдохуйц байдлаар тайлагнах
5. Тайлангийн хавсралтад нотолгоо болж чадахуйц зураг, батлагдсан баримт бичгийн файлыг оруулах
6. Баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан тайланг хянаж, засаж сайжруулсны үндсэн дээр баталгаажуулдаг байх

### 3.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн **431** зорилт, арга хэмжээний биелэлтийг тооцоход үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй ажил арга хэмжээ **334**, тодорхой үр дүнд хүрсэн **48**, эрчимжүүлэх шаардлагатай **38**, хэрэгжээгүй **9**, хугацаа болоогүй **2** ажил арга хэмжээ байгаа бөгөөд 2023 жилийн эцсийн байдлаар нийт ажлын гүйцэтгэл **87.8** хувийн хэрэгжилттэй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах	7	98.6
<b>ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>		
2.1. Эрүүл мэнд	42	92.3
2.2. Биеийн тамир, спорт	9	86.6
2.3. Боловсрол	32	92.5
2.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил	21	90.9
2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	22	95
2.6. Үндэсний бахархал, өв соёл	12	75.8

ГУРАВ.ЭДИЙН ЗАСАГ		
3.1. Санхүү, төсвийн зохицуулалт	10	95
3.2. Уул уурхай, хүнд үйлдвэр	8	72.5
3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	56	91.5
3.4. Аялал жуулчлал	12	86.6
3.5. Тээвэр, логистик	5	40
3.6. Барилга, хот байгуулалт	33	73.9
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ		
4.1. “Цахим Сүхбаатар” төрийн шуурхай үйлчилгээ	20	96
4.1. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба	8	96.7
4.3. Амар тайван, аюулгүй нийгэм	28	94.6
4.4. Тогтвортой, нэгдмэл гадаад харилцаа	17	66.4
4.5. Батлан хамгаалах	6	91.6
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ		
5.1 Ногоон хөгжил	37	93.2
ЗУРГАА. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ		
6.1. Баруун-Урт хот	30	88.3
6.1. Сумдын хөгжил	17	65

## **ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

### **4.1.Сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Захиргааны байгууллагын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ хийхэд тайлангийн баталгаажуулалтын хэлбэр алдаатай, зорилт арга хэмжээ, суурь түвшин, хүрэх түвшингийн илэрхийлэх утга буюу хэмжих нэгж зөрүүтэй, төсвийн шууд захиргачийн үнэлгээг журмын дагуу өгөөгүй, төлөвлөгөөний хэсэг тус бүрийн үнэлгээг нэгтгээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд гарч байна. Иймээс захиргааны байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжүүд жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд дээрх алдааг гаргахгүй байхад анхаарч Засгийн газрын 2020 оны 217-р тогтоол, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн тайлан бичих чиглэлээр тусгайлан зөвлөгөө, зөвлөмж авах шаардлагатай байна.

Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.

#### **Нийтлэг шаардлага**

- Зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц байх
- Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зорилтдоо чиглэсэн байх
- Арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэр тодорхой байх
- Шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц / SMART / байх
- Судалгаа, шинжилгээнд суурилсан байх
- Мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан байх
- Тоон мэдээлэл нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх
- Төрийн үйлчилгээг чанартай, хурдан шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн байх
- Хууль тогтоомжид нийцсэн байх

### **4.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт**

Тухайн жилд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үнэлэхэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг 90,2, төсөвт байгууллага 91,9, сум 91,9 хувийн биелэлттэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 55.3-т Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасаны дагуу:

- ✓ Байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- ✓ Ажлын байрны сэтгэл ханамжийн санал, судалгааг жил бүр авч түүний мөрөөр ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.
- ✓ Жил бүр тодорхой зорилтын хүрээнд ажилтнуудынхаа эрүүл мэндийн асуудалд анхаарах, төрөлжсөн болон багц шинжилгээ, үзлэгт хамруулах.
- ✓ Ажилтнуудын сургалт хөгжлийн үйл ажиллагаа, нийгмийн асуудалд зарцуулах тодорхой зардал төсөвлөн батлуулах.

#### 4.3. Орон нутгийн шийдвэрийн хэрэгжилт: (Аймгийн ИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамж, албан даалгаварын биелэлт:)

2023 оны аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг журмын дагуу бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хэрэгжилтийн хугацаа болоогүй гэсэн аргачлалаар тооцож дүгнэхэд сум 87.75 хувь, агентлаг, төсөвт байгууллага 90.34 хувьтай нийт дундаж: 89.04 хувийн хэрэгжилттэй байна.

№	ЗДЗ- АД	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Үнэлгээ өгөгдөөгүй	Биелэлтийн хувь
1	Сум	768	942	622	262	28	15	15	0	87,75
2	Агентлаг	726	899	594	166	25	8	34	0	90,34

#### Аймгийн ИТХ-ын тогтоол:

2023 оны үнэлгээгээр сум 87,75, агентлаг, төсөвт байгууллага 90,34, нийт дундаж 87,35 хувийн хэрэгжилттэй байна.

№	ЗДЗ- АД	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Үнэлгээ өгөгдөөгүй	Биелэлтийн хувь
1	Сум	157	157	98	53	3	3	-	-	86,63
2	Агентлаг	134	134	81	36	2	2	3	-	88,06

### ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

#### 5.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт:

Мэдээллийн ир тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ЗГ-ын 206, 352 дугаар тогтоолоор баталсан үйл ажиллагаа, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд сумын дундаж 87.8, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг 86.8, төсөвт байгууллага 89.0 нийт дундаж 87.8 хувийн хэрэгжилттэй байна.

№		Шалгуур үзүүлэлт	100 %	70%	30%	0%	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Дундаж хувь
1	Сум	46	349	184	15	8	42	86.6

2	Агентлаг	46	653	301	12	6	270	86.8
3	Төсөвт байгууллага							89.0
Дүн								87.8

Цахим сайттай байгууллага 24

Цахим сайттай сум 13

Цахим сайтгүй байгууллага 4

Тайлан ирүүлээгүй байгууллага 1

Хугацаа хоцроосон байгууллага 3

Аймгийн хэмжээнд дийлэнх сум, байгууллага албан ёсны вэб сайттай байгаа боловч байнгын ажиллагаатай, стандартын шаардлага хангасан вэб сайт ажиллуулж байгаа нь цөөхөн, 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр 11 байгууллага, 3 сумын цахим хуудсанд нэвтрэх боломжтой, бусад цахим сайтууд ажиллагаагүй байсан.

### 5.2.Шилэн дансны хэрэгжилт:

2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийн үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас авч ашиглав. Сум дундаж 94.7, агентлаг байгууллага 96.6, төсөвт байгууллага 96.86, нийт дундаж үнэлгээ 96.05 хувийн хэрэгжилттэй, өмнөх оноос 4,9 хувиар ахисан үр дүнтэй байна. / 2022 онд 91,1 хувь/

ШД-ны хэрэгжилтийн чанарын байдалд ХШ хийхэд гарсан нийтлэг дутагдлууд:

- Төсвийн хэтрэлт хэмнэлтийн зөрүү тайлбарыг бичээгүй
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан оруулаагүй
- Дараа жилийн төсвийн төслөө дутуу оруулсан
- мэдээллийг хуулийн хугацаа хоцроох, хагас дутуу мэдээлэл оруулах зэрэг нийтлэг зөрчил дутагдлууд байна.

### ЗУРГАА: ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Төр, орон нутгаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмж, хүнд сурталгүй шуурхай хүргэж байгаа талаарх иргэдийн хандлагыг тандан судлах зорилгоор “Хэрэглэгчийн үнэлгээ” судалгааны ажлыг “Өсөх сэтгэлгээ өнгөлөг ирээдүй” НҮТББ аймгийн 929 өрхөөс түүвэрлэн судалгаа авахад 71.5 буюу өмнөх оноос 0.8 хувиар өссөн.

Сумын нэр	Өрхийн тоо	Үнэлгээ
Асгат	30	72.9
Баруун Урт	413	69.0
Баяндэлгэр	55	66.9
Дарьганга	43	68.1
Мөнххаан	62	77.7
Наран	29	74.8
Онгон	44	68.3
Сүхбаатар	32	78.9
Түвшин	33	74.0
Түмэнцогт	44	77.6
Уулбаян	39	76.8
Халзан	36	72.1
Эрдэнэцагаан	69	70.4
Нийт	929	71.5



## Салбарын дундаж үнэлгээ

Сумдын 2023 оны үйл ажиллагаанд дараах шалгуураар салбарын дундаж үнэлгээ дараах шалгуурын хүрээнд холбогдох агентлагуудаас хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэн үнэлсэн: Үүнд

1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилт
2. Хог хаягдлын менежмент
3. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ
4. ЕБС, СӨБ-ын үйл ажиллагааны үнэлгээ
5. Газар зохион байгуулалт, иргэдэд өмчлөх газрыг шийдвэрлэсэн байдал
6. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, үр дүн
7. Албан болон сайн дурын даатгалд хамрагдсан байдал
8. Соёлын төвийн үйл ажиллагаа
9. Статистик мэдээ, тооллого, ХАОМС-ын чанар
10. Татварын орлого төвлөрүүлэлт, төлөвлөлт
11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн
12. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт
13. Нийгмийн халамжийн сангаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн
14. ХАА-н салбарын үйл ажиллагаа
15. Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа
16. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ
17. Хамтарсан багийн үйл ажиллагаа
18. Хүүхэд хөгжил хамгааллын хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээ
19. Бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулсан үнэлгээ
20. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, илрүүлэлтийн хувь
21. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар
22. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх арга хэмжээний гүйцэтгэл

## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/343 дугаар захирамжаар баталсан “Сүхбаатар аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу сум, агентлаг, төсөвт байгууллагын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэв.

2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээг хүснэгтээр нэгтгэн харуулбал: Сум:

№	Үзүүлэлт		Хэрэгжилт ийн хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	84,7
		Аймгийн ЗД-ын үйл ажмиллагааны хөтөлбөрийн биелэлт	81,5
		Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	80,0
		Сумын ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	85,5
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	86,2
		Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилт	87,7
		Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт	86,6
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	91,9
		Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, ОНХС-н үйл	81,5

		ажиллагааны гүйцэтгэл, үр дүн	
		Тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний үнэлгээ	80,8
		Салбарын дундаж үнэлгээ (холбогдох агентлагуудаас өгсөн үнэлгээ)	80,2
		Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	80,1
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын нээлттэй, ил тод байдлын үнэлгээ	86,6
		Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	95,5
		Хэрэглэгчийн үнэлгээ	72,9
Ерөнхий үнэлгээ			84,1

Агентлаг, төсөвт байгууллага:

№	Үзүүлэлт	Хэрэгжилт ийн хувь	
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	91,7
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	87,8
		Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	87,6
		Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	88,6
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	86,6
		Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилт	90,1
		Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт	87,9
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	90,6
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	87,2
		Байгууллагын нээлттэй, ил тод байдлын үнэлгээ	87,8
		Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	96,0
Ерөнхий үнэлгээ		89,3	

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжих хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 4 заалт, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний эрчимжүүлэх шаардлагатай 8 арга хэмжээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээр үр дүнгүй гэж үнэлэгдсэн 7 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч 2024 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, бүрэн мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарах, хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж хэрэгжүүлэх, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

### НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Сумд, агентлаг, төсөвт байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

-Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд:

- ЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 45 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу: холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд улирал бүр үнэлгээ дүгнэлт хийж, хангалтгүй буюу хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гарган улирал бүр хэрэгжилтийг тооцож ажиллах

## 2. Аймгийн хөгжлийн төлөвлөгөө

- Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг улирал бүр тооцон, байгууллагын дарга, сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ажил, арга хэмжээг эрчимжүүлэх

## 3. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил

- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явц гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн хувь, гүйцэтгэлийг улирал бүр тооцон Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ажил, арга хэмжээг эрчимжүүлэх

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын байгуулсан гэрээ түүний биелэлтийн тайланг хянан үзэхэд, гүйцэтгэлийн төлөвлөгөө стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй, зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй буюу хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжих тоон ба чанарын утгыг тодорхойлоогүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаагаагүй, арга хэмжээ бүрийг тоочих байдлаар тайлагнасан, үр дүн, хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй зэрэг дутагдалтай асуудлууд байгаас гадна доор дурьдсан асуудлуудыг цааш анхаарч ажиллахыг зөвлөж байна.

- Хэтэрхий олон ажил төлөвлөхгүй байх.
- Зарим байгууллага 178 ажил, арга хэмжээ төлөвлөсөнөөс ихэнхи нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой ажил төлөвлөж байна.
- Ажил, арга хэмжээ төлөвлөхдөө тухайн байгууллагынхаа үндсэн үүрэгтэй холбоотой аймгийн хэмжээнд ахиц дэвшил гарахуйц гол томоохон ажлаа төлөвлөх.
- Ажил, арга хэмжээ нь хэмжигдэхүйц байх.
- Дээд байгууллагаас ирсэн төлөвлөлт гээд шууд хуулж тавихгүй байх.
- Зарим арга хэмжээнд захирамж гаргаад өөр ямар нэгэн үр дүнд хүрсэн ажил зохион байгуулахгүй орхиж байна.
- Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан хэрэгжээгүй болон хэрэгжилт удааширалтай байгаа ажлуудаа түлхүү төлөвлөх, шаардлагатай төсөв батлуулж ажиллах.
- Үр дүн гараагүй, зөвхөн шийдвэр гаргаад орхисон ажлаа 100 хувийн биелэлттэй гэж тайлагнаж байна.

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах,

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;

3. Байгууллагын цахим хуудсыг “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандарт”-ын дагуу хөтөлж, хэвшүүлэх.

4. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, албан хаагчийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

5. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх зэрэг болно.